



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тойруу, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Засгийн газрын V байр,
Утас: 260095, Факс: (976-11) 260042

2024.03.05 № 02/81

танай _____-ны № _____-т

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталсан 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хагас болон бүтэн жилээр гарган ирүүлж, хамтран ажиллана уу.

Холбоо барих:
Ахлах мэргэжилтэн Г.Амаржаргал
Цахим хаяг: amarjargal.g@mojha.gov.mn
Утас: 265125, 99749934

Хавсралт 6 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.АМАРБАЯСГАЛАН



БАТЛАВ.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.АМАРБАЯСГАЛАН

2024 оны 02 сарын 22 өдөр

9020100526
8631576 & СБТ11938

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төсөв	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Зорилтот түвшин
Нэг. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд						
1.1	Дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
1.2	Хүн худалдаалахтай холбоотой гарсан журмын зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэх болон Хүний эрхийн багц хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан, хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийн саналыг хүргүүлэх	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ГХУСАЗЗАА	ХЗДХЯ	Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын тайлан холбогдох байгууллагад хүргэгдэж, шаардлагатай арга хэмжээ авагдсан байна.
1.3	Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт тусгах	Жилдээ	Улсын төсөв	ГХУСАЗЗАА	Сангийн яам	Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр 2024 оны улсын төсөвт тодорхой санхүүжилт тусгасан, нээлттэй худалдан авах ажиллагаа явуулсан байна.

1.4	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөл боловсруулах	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ГХУСАЗЗАА ОУБ	Дэд зөвлөлийн гишүүд	Төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан байна.
Хоёр. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах хүрээнд						
2.1	"Хүн худалдаалахын төлөв байдал" судалгааны ажил хийлгэх	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүн байгууллагууд	Судалгааны ажлын үр дүнг нийтэд түгээсэн байна.
2.2	"Цахим орчин үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх нөхцөл байдал" судалгааны ажил хийлгэх	Эхний хагас жилд	Төслийн зардлаар	ОУШХБ	ГХУСАЗЗАА	Судалгааны үр дүн гарч, танилцуулагдсан байна.
2.3	"Албадан хөдөлмөрлүүлэх болон түүнтэй төстэй гэмт хэргийн нөхцөл байдал" судалгааны ажил хийлгэх	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	УЕПГ	ГХУСАЗЗАА, ОУБ	Судалгааны ажлын үр дүнг холбогдох эрх бүхий этгээдэд танилцуулж, үр дүн гарсан байна.
2.4	"Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журам"-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлгэх	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ХХЕГ ЦЕГ	ГХУСАЗЗАА	Журмын хэрэгжилтийг үнэлж, шинэчлэн боловсруулсан байна.
2.5	Цахим орчинд үйлдэгдэж буй хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий сэрэмжлүүлэг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэх	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ЦХХХЯ ХХЗХ	ТЕГ, ЦЕГ	Цахим орчинд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ 2-оос доошгүй удаа зохион байгуулагдсан байна.
2.6	Цахим орчинд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн болон биеэ үнэлэхийг зохион байгуулж буй цахим хуудсуудыг илрүүлэх, таслан зогсоох ажлыг тухай бүрд зохион байгуулах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ЦХХХЯ, ТЕГ, ЦЕГ	ХХЗХ	Цахим орчинд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг зохион байгуулж буй цахим хуудсуудыг тухай бүр илрүүлэх арга хэмжээг авч, дахин гэмт хэрэг үйлдэгдэх нөхцлийг

						таслан зогсоох арга хэмжээг авсан байна
2.7	Биеэ үнэлэхийг зохион байгуулдаг саун, массажны газар, зочид буудал, түрээсийн байр, караоке, шөнийн цэнгээний газар, алжаал тайлах төв зэрэг газруудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ЦЕГ	ТЕГ, ГХУСАЗСЗ	Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг эрх бүхий этгээдэд танилцуулсан байна.
2.8	Бүх шатны боловсролын байгууллага, соёлын төв, номын сангийн мэдээллийн самбар, цахим хуудаст хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас, богино хэмжээний шторк, сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	БШУЯ Соёлын яам	ГХУСАЗЗАА, ЦЕГ	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургууль, соёлын төв, номын санд урьдчилан сэргийлэх агуулга бүхий мэдээллийг байршуулсан байна.
2.9	Нисэх буудал, төмөр замын буудал болон олон улсын чанартай хилийн боомтуудад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг мэдээлэл түгээх	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ГХУСАЗЗАА, ОУБ	ХХЕГ, ТЕГ, ТББ	Хилийн боомт бүхий газарт урьдчилан сэргийлэх мэдээлэл тогтмол байрлуулсан байна.
2.10	Эрүүгийн цагдаагийн албаны хүн худалдаалахтай тэмцэх нэгжийн чадавхийг үнэлэх судалгааны ажил хийлгэх	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ЦЕГ, ОУБ	ГХУСАЗЗАА	Судалгааны ажлын үр дүнг холбогдох эрх бүхий этгээдэд танилцуулж, үр дүн гарсан байна.
Гурав. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сочин гэгээрүүлэх ажлын хүрээнд						
3.1	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аялал жуулчлал, агаарын тээвэр, төмөр зам, авто тээвэр, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын албан хаагчдын	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ ГХУСАЗЗАА	ЦЕГ, ХХЕГ Салбар дундын хамтарсан баг	Зорилтот бүлэгт чиглэсэн 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулагдсан байна.

	мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах					
3.2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч (хүүхэд) төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” улсын хэмжээний сургалтыг зохион байгуулах	Эхний хагас жилд	ХХТК төслийн зардлаар	ГХУСАЗЗАА	ЦЕГ, ОУБ	100-аас доошгүй хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчдыг сургасан байна.
3.3	Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур, Хавирга, Замын-Үүд, Сүмбэр, Баянхошуу боомтод ажиллаж буй албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголт эзэмшүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх, шаардлагатай туслалцааг үзүүлэх сургалт зохион байгуулах	Эхний хагас жилд	ХХТК төслийн зардлаар	ГХУСАЗЗАА	ХНХЯ, ХХЕГ, ГЕГ, ЦЕГ, ДХИС, ОУБ, ТББ	100-аас доошгүй албан хаагчид ХХГХ-ийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургалт зохион байгуулагдсан байна.
3.4	Цахим орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал сэдэвт сургалт зохион байгуулах	Жилдээ	ОУБ-ын зардлаар /ХХТК/	ГХУСАЗЗАА, ОУШХБ, ОУБ	УЕПГ, ЦЕГ	Хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.
3.5	Форензик ярилцлага хийх үндэсний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Эхний хагас жилд	ХХТК төслийн зардлаар	ГХУСАЗЗАА, ОУБ	ХНХЯ, ЦЕГ	Форензик ярилцлага хийх сургалтыг зохион байгуулж, сургагч багш бэлтгэгдсэн байна.
3.6	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэдтэй ажиллаж буй нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд зориулсан сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулах	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ХНХЯ, ОУБ	ГХУСАЗЗАА, ЭМЯ, ШШГЕГ, ШШЕГ, ХГБХХЕГ	Сэтгэл зүйн сургалт зохион байгуулагдсан байна.
3.7	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцоход анхаарах асуудал сэдэвт сургалт зохион байгуулах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	УЕПГ	ХГБХХЕГ	ХГБХХЕГ-ын харьяа байгууллагуудын албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.

Дөрөв. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд						
4.1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй түр хамгаалах байрны үйл ажиллагаанд мониторинг хийлгэх	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ХНХЯ, ГХУСАЗЗАА	ЦЕГ, ХГБХХЕГ, ОУБ, ТББ	Түр хамгаалах байраар үзүүлж буй үйлчилгээнд үнэлгээ хийгдэж, цаашид үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх санал танилцуулсан байна.
4.2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээг туршилтаар хэрэгжүүлэх	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	ХНХЯ, ХГБХХЕГ	ГХУСАЗЗАА, ОУБ, ТББ	3-5 хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээг туршин хэрэгжүүлсэн байна.
4.3	Гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэдэд туслах, холбон зуучлах талаар Дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудыг сургах, хохирогч болсон иргэдийг эх оронд нь эгүүлэн авчрах	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ГХЯ	ТЕГ, ЦЕГ, ГИХГ, УБЕГ, ГХУСАЗЗАА, ОУБ	Гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэнд шаардлагатай үйлчилгээг үзүүлэх чиглэлээр чадавхжсан байна.
4.4	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын түр хамгаалах байрны үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих	Жилдээ	Үйл ажиллагааны зардлаар	ХНХЯ, ГХУСАЗЗАА	ЦЕГ, ОУБ, ТББ	Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч, хохирогч хамгаалагдсан байна.
Тав. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд						
5.1	АНУ-ын Төрийн департаментаас жил бүр эрхлэн гаргадаг Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тайланд мэдээлэл хүргүүлэх	IV улиралд	Үйл ажиллагааны зардлаар	ГХУСАЗЗАА	ЦЕГ, ТББ	Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтэст тайлан, мэдээлэл хүргүүлсэн байна.
5.2	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах	Жилдээ	ХХТК төслийн зардлаар	УЕПГ, ХЗДХЯ, ХНХЯ, ГХУСАЗЗАА	Оролцогч талууд	Хүүхэд хамгааллын компакт гэрээний хэрэгжилтийг бүрэн хангасан байна

5.3	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Жилдээ	Төслийн зардлаар	ОУХБ	ГХУСА33АА	Төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна
5.4.	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран Цахимаар үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хянан шалгах ур чадварыг бэхжүүлэх нь төслийг хамтран хэрэгжүүлэх	Жилдээ	Төслийн зардлаар	ОУШХБ	ГХУСА33АА	Төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна

--o0o--